

Аллан Нфамба: Хүрэлцэн ирсэн нийт хамтран ажиллагсаддаа талархал илэрхийлье. Монгол улсад хүрэлцэн ирэх бүрт та бүхэн найрсагаар хүлээн авч, хичээл зүтгэлтэйгээр хамтран ажилладагт тань баярлалаа. Магадгүй оройтсон байх гэхдээ та бүхэнд бүгдэд нь Монголын улсамжлалт цагаан сарын мэнд хүргэе. Юуны өмнө Сүрьеэгийн төсөлд 1,5 сая ам.долларын нэмэлт санхүүжилтийн хүсэлтийг ГС-ийн Төсөл батлах хороонд хүргүүлсэн та бүхэнд баяр хүргэе. Энэ бол МУ-ын хувьд нилээд томоохон амжилт байлаа. Энэхүү санхүүжилттэй холбоотойгоор та бүхэнд ерөнхий нэмэлт ойлголтыг өгөхийг хүсэж байна.

2017 оны 12 сард Глобаль Сан болон Азийн Хөгжлийн Банк хамтран дээд хэмжээний хамтын ажиллагааны гэрээг байуулсан. Энэ үйл ажиллагааны хүрээнд хамтрагч талууд нэг нэгийнхээ хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд дээр хамтран ажиллах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, ГС-ийн хувьд АХБ-ны ажиллаж буй азийн бүсийн орнуудад нэмэлт санхүүжилтыг олгох чиглэлээр ажиллаж байна. ЭМ-ийн чиглэлээр бид тусдаа хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Тиймээс эдгээр хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлсэнээр илүү үр дүнтэй, санхүүгийн хувьд өндөр үр ашигтай, цаашид хэрэгжүүлж буй эдгээр хөтөлбөрүүдийн тогтвортой байдлыг хангах үүднээс энэхүү хамтын ажиллагааг эхлүүлээд байна. Та бүхний ихэнх нь энэхүү 1,5 сая ам.долларын санхүүжилт хэрхэн зарцуулагдах талаар мэдээлэлтэй байгаа байх. Тодруулбал:

- Глобаль сангийн хөрөнгө оруулалт 500,000 ам. доллар –Энэ нь АХБ вируст гепатитын төслийн гепатитын оношилгоо, эмчилгээний чадавхи сайжруулах төсөлтэй хамтарсан хөрөнгө оруулалт хийж, улмаар Монгол улсын бүх эрүүл мэндийн ажилтнуудын сүрьеэгийн үзлэг, оношилгоо, эмчилгээ болон сүрьеэ өвчний талаар хандуулах анхаарлыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилгоор хамтарсан мэдээлэл, мэдлэг, харилцааны үйл ажиллагаагаар дамжуулан сүрьеэгийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр зарцуулагдах болно.

Сүүлийн хэдэн өдөр бид АХБ-наас вируст гепатитын оношилгоо, эмчилгээний чадавхи сайжруулах төслийг хэрэгжүүлж байгаа багтай уулзаж ярилцсан. Тус уулзалтаар энэ төслийг хэрхэн хэрэгжүүлэх зохицуулалтын талаар ярилцсан бөгөөд тухайн баг сургалтыг хөтөлбөрийг боловсруулан сургалтын багцийг бий болгон ажилласан байсан. Хамгийн гол нь тэдгээр сургалтын багцийг бэлтгэхдээ МУ-ын орчин нөхцөлд тохируулан, дараа дараагийн сургалтуудыг хэнд зориулан хүргэхээ сайтар бэлтгэсэн байсан ба ЭМ-ийн ажилчдыг сургах бэлтгэл ажлаа аль хэдийн дуусаад, одоо ЭМ-ийн 1, 2-р шатлалын эмч нарыг сургах сургалтын үйл ажиллагаандаа шилжиж байсан. Бидний хувьд тэдний туршлагыг ашиглан Сүрьеэгийн цогц сургалтын хөтөлбөрийг боловсруулж хүмүүсээ бэлтгэн, дараагийн удаа сургалтанд Гепатит болон сүрьеэгийн цогц сургалтыг зохион байгуулж чадна гэдэгт итгэлтэй байна. Мэдээж энэхүү төслийг ЭМЯ хэрэгжүүлэх бөгөөд, ДЭМБ-аас техникийн туслалцаа авах, хөтөлбөрийг боловсруулах цаашлаад сургалтыг хэрхэн хийх талаар хамтран ажиллана. Миний хувьд эргэн очоод эдгээр үйл ажиллагааг аль болох хурдан эхлүүлэх талаар анхааран ажиллана. Төсвийг батлах хороонд бичиг баримтыг өгсөнөөс хойш тодорхой хэмжээний цаг зарцуулагддаг. Өнөөдрийн хувьд бид 500,000 ам.долларын санхүүжилтыг л ярьж цаашид энэ санхүүжилтээ Төсөл батлах хороонд хүргүүлнэ.

Глобаль сангийн хөрөнгө оруулалтын үлдсэн 1,000,000 ам.доллар бол АХБ-ны Бусад үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа- Эрүүл мэндийн анхан болон хоёрдогч шатлалын түвшинд сүрьеэгийн болон ХДХВ-ийн тусламж үйлчилгээг нэгтгэх төслийн хүрээнд нэмэлтээр олгоно.. Ингэхдээ АХБ МУ-ын ЗГ-т олгох зээл дээр нэмэлт урамшуулал байдлаар олгох болно. Энэхүү АХБ-ын зээл дараа долоо хоногоос батлагдана гэж үзэж байна. Тиймээс энэ оны 4 сард энэхүү 1 сая ам.долларын төслийг Төсөл батлах хороонд танилцуулна.

Түүнчлэн ҮЗЗ-ийн даргад энэхүү 1,5 сая ам.долларын санхүүжилтын хүсэлтийг маш богино хугацаанд, чанартай бэлтгэж ирүүлсэнд талархал илэрхийлэхье. Бидний зүгээс тус санхүүжилтын хүсэлтийг гаргах хугацааг давчуу тавьсан. АХБ-тай хамтран ажиллах энэхүү төслийг алсын хараатай, томоохон үр нөлөөтэй ажил гэж үзэж байна. Глобаль Санд илгээх баримт бичгүүд:

- Төслийн төсвийн шинэчилсэн хураангуй;
- Төслийн шинэчилсэн гүйцэтгэлийн хүрээ

Глобаль Сангийн төсөл батлах хороод эхний ээлжинд 500000 ам.долларын хүсэлтийг

хүргүүлэх хугацаа :

Төсөл батлах хорооны хурал	Баримт бичгийн эхний саналыг өргөн барих хугацаа	Баримт бичгийг эцсийн байдлаар өргөн барих хугацаа
2-р сарын 21	2-р сарын 7	2-р сарын 14
3-р сарын 14	2-р сарын 28	3-р сарын 7

Дараа нь бид 1 сая ам.долларын санхүүжилтын хүсэлтийг 4 сард хүлээн авч цааш уламжлах болно.

Энэ дашрамд ҮЗЗ-д ГС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд удирдлагаар ханган ажиллаж байгаад талархал илэрхийлье. ҮЗЗ-ийн дэмжлэг, манлайллаар сүрьеэгийн чиглэлээр томоохон ажлууд хийгдэж байна. Жишээлбэл: Сүрьеэгийн Үндэсний хэмжээний томоохон уулзалтыг зохион байгуулж, ухуулга нөлөөллийн чиглэлээр өндөр төвшинд ярилцжээ. Сэлэнгэ аймагт иэвхитэй илрүүлгийг хийж эхэлсэн болон улс орны хэмжээний сүрьеэгийн эмч нарын цалин нэмэгдсэнд баяртай байна. Гэхдээ цаашид бид ХДХВ/ДОХ-ын чиглэлийн ухуулга нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна. Ялангуяа түлхүүр хүн амд чиглэсэн үйл ажиллагааг сайжруулах хэрэгтэй байгаа.

ҮЗЗ-ээс улс төрийн дээд төвшинд Түлхүүр хүн амд чиглэсэн олон орны хамтарсан төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн энэ хүн амд эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чухал гэдэг талаар ухуулга, нөлөөлөл хийж, цаашдын хэрэгжилтэнд анхааран ажиллахыг хүсэж байна. ГС-ийн зүгээс энэхүү төслийн Үндсэн Хүлээн Авагч болох Австралийн ДОХ-ын Холбоотой гэрээг байгуулж байгаа бөгөөд тэдний зүгээс төслийн СХА-тай гэрээг байгуулан ажиллаж байна. Түүнчлэн ҮЗЗ-д түлхүүр хүн амд зориулсан санхүүжилтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах хүсэлтийг тавьмаар байна. Ялангуяа Шилжилтын үеийн төлөвлөгөө, цаашдын тогтвортой байдлыг хангахад хамтарч ажиллаарай. Бидний зүгээс ДОХ-ын тооцооллыг хийх аль хөрөнгө оруулалт илүү ашигтай байх талаарх сургалтууд хийгдсэн. Мөн сүрьеэгийн чиглэлээр эдгээр сургалтыг хийхээр төлөвлөж байна. Бидний зүгээс ДОХ, сүрьеэгийн чиглэлээр дээрх тооцооллыг ашиглан шилжилтын үеийн төлөвлөгөө боловсруулах тал дээр техникийн туслалцаа үзүүлнэ. ЭМЯ маш сайн мэдээлэл бүхий нотолгоонд суурилсан шилжилтийн төлөвлөгөөг боловсруулахад тусална. Тиймээс төсөл хөтөлбөрийн цаашдын тогтвортой үйл ажиллагаанд анхаарах хэрэгтэй байна.

Одоогийн хэрэгжүүлж буй төслүүдийн хэрэгжилтэнд ҮЗЗ-ийн зүгээс гаргаж буй чармайлт, манлайлалд талархал илэрхийлэхийн сацуу цаашид хэрэгжих ХДХВ/ДОХ, сүрьеэгийн төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэхэд хүчин чармайлтаа үргэлжлүүлэн гаргана гэдэгт итгэж байна. Баярлалаа.

Хариулт:

Б.Мягмар: Бүсийн менежер Аллан Нфамба танд маш их баярлалаа. ҮЗЗ болон хамтрагч талуудад олон сайхан урмын үг хайрлалаа. Түүнчлэн цаашид бидний анхаарах асуудлыг нилээд бодож боловсруулан нэгтгэж тодорхой хэлсэнд баярлалаа. МУ-ын ард түмэнд Глобаль Сан асар их хөрөнгө оруулалтыг хийж МУ-ын авч явж чадахгүй байгаа томоохон хэсгүүдийг авч явахад маш том дэмжлэг болж байна. Бидний хувьд их чухал цагт ГС-ын нэмэлт санхүүжилтийг олгох гэж байгаа нь маш том дэмжлэг, үүнийг үр ашигтай, үр дүнтэй цаашид тогтвортой байлгах чиглэлээр ҮЗЗ-ийн гишүүд, мөн энэхүү хуралд оролцож байгаа ЭМЯ, ХЗН, СХА зэрэг бүх байгууллагууд идэвхи чармайлттай ажиллана гэдэгт эргэлзэхгүй байна. Бидний хамтын ажиллагаа улам ойртон, нягтарч байгаад ҮЗЗ-ийн даргын хувьд бүх хүмүүстээ талархал илэрхийлж байна. Бүсийн менежертээ ажлын өндөр амжилтыг хүсье. Бид бүхэн таны өгсөн үнэтэй заавар зөвлөгөөг даган мөрдөж, хамтарч ажиллах болно.

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар

Зөвшилцөл

х

Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх	
			Нууц санал хураалт	
		Дэмжсэн>		
		Эсрэг>		
			Санал өгөхөөс түдгэлзэх	

Хөтөлбөр #3	Сүрьеэгийн төслийн 1,5 сая ам.долларын нэмэлт санхүүжилтын талаар мэдээлэл өгөх,-Асуулт, хариулт
--------------------	---

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>

Үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

Т.Энхзаяа, НЭМГ-ын дарга, Сүрьеэгийн төслийн нэмэлт санхүүжилтын Ажлын хэсгийн ахлагч: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

2018 оны 12 сард сүрьеэгийн эрт илрүүлгийг хийж, ард иргэддээ сүрьеэгийн мэдээлэл, сургалт, сурталчилгааг цогц байдлаар хүргэе гэсэн саналыг нааштайгаар хүлээн авч, ЭМЯ МУ-ын ЗГ-тай хамтран энэ төслийг хэрэгжүүлэх чадамжтай гэж үзсэнд баяртай байна. АХБ Хепатитын төслийн үйл ажиллагааг МУ-д маш амжилттай хэрэгжүүлж байгаа ба салбарын анхан болон хоёр дахь шатлалын эмч нарыг сургах сургалтанд тулгуурлан тус төслийг хэрэгжүүлэх нь маш ухаалаг алхам болсон бөгөөд үүнийг ГС-аас алсын хараатай харж хамтран энэ төслийг хэрэгжүүлэх гэж байгааг дурдахад таатай байна.

2019 онд бид нилээд ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байгаагын нэг нь шилжилтийн үеийн төлөвлөгөөг боловсруулах ажил багтсан болно. Түүнчлэн энэ жил түлхүүр хүн ам, эрсдэлт бүлгийн хүн амын дундах эрт илрүүлгийг эрчимжүүлэн ажиллана. Учир нь 2018 онд тархалтын судалгаа 5 газар хийгдсэн Сүрьеэгийн эрт илрүүлгийн судалгаанд тулгуурлаж сүрьеэгийн түлхүүр хүн амын судалгаанд чиглэгдсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлтэнд хүрсэн. Мөн энэ жил сүрьеэгийн тохиолдол илэрсэн сургуулиуд дээр үйл ажиллагаагаа эрчимжүүлж, илрүүлэг үзлэгийг хийх болно. Мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд, телевиз, радио, цахим мэдээллийн хэрэгслүүдээр явуулж байгааг та бүхэн олж харах болно.

Энэхүү 1,5 сая ам.долларын санхүүжилтын хүрээнд 1 сарын 28-нд болсон ҮЗЗ-ийн Гүйцэтгэх хорооны хурлаар бид ажлын хэсгийн гишүүдээ томилсон. Түүнчлэн Аллан ирсэнтэй холбогдуулан нилээд олон уулзалтыг АХБ-тай хийсэн. Ингээд бид эхний байдлаар энэ санхүүжилтыг хэрхэн хууваарилсан талаарх мэдээллийг С.Ганзаяа, ХЗН-ийн Сүрьеэгийн төслийн мэргэжилтэн та бүхэнд танилцуулах болно.

С.Ганзаяа, ХЗН-ийн Сүрьеэгийн төслийн мэргэжилтэн /Хавсралт №1/ Сүрьеэгийн төслийн 1,5 сая ам.долларын нэмэлт санхүүжилтын талаар мэдээлэл өглөө.

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

МҮЭ	Б.Мягмар: 1. Төслийн төсвийн шинэчилсэн хураангуй дээр тогтолцоо, хүний нөөцийн зардал 10% байгааг тайлбарлана уу. 2. Санхүүжилтын гол зорилго бол Хүний нөөцийг бэхжүүлэх, Эрүүл мэндийн тогтолцоо, Ханган нийлүүлэлт гэтэл ханган нийлүүлэлт 1% байхад менежментийн зардал яагаад 10% байна вэ?
-----	---

ДЭМБ	П.Анузаяа: Төслийн төсвийн шинэчилсэн хураангуйн дагуу ХШҮ өөрчлөгдөж байгаа тэгэхээр үүн дээр 2 шалгуур үзүүлэлтүүдийг шинэчилжээ. Үүнд: 1. Эмчилгээний хамрагдалт болон шинэ тохиолдлын тоо: үүнээс 2019-2020 онд Эмчилгээний хамрагдалтыг 5%-аар өсөх талаар дурджээ. 2. Үзүүлэлт дээр харагдаж байгаа тоогоор шинэ тохиолдлын тоог жилдээ 10%-аар нэмэгдүүлнэ гэсэн байна. Эдгээрийг ямар нарийвчилсан тооцоолол, үндэслэл, шалгуур үзүүлэлтээр гаргасан бэ?
------	--

	Эдгээр үйл ажиллагаанууд хэрэгжих хугацаа давчдаад байхад эргээд шилжилтийн төлөвлөгөөтэй уялдуулан цаашид өвчлөлийн байдлыг хянах, дээрээс нь төлөвлөж буй үйл ажиллагаанд хэр сайн үр дүнтэй зарцуулж хэрэгжүүлэх байдлыг үндсэн үйл ажиллагаатай хэрхэн яаж уялдуулсан бэ?
Х/хэвшил	Б.Сувд: 1-т Эрсдэлт бүлгийн хүн амд мобайл технологи ашиглах гэж юу гэсэн үг вэ? 2-т Хүний нөөцийг бэхжүүлэх гэж орсон байгааг орчин нөхцлийг сайжруулах, резидент эмч нарыг сургах гэдэг юмуу? Яг бэхжүүлэх гэдэг үгээр юу илэрхийлсэн бэ гэдгийг тодруулах гэсэн юм.
Хариулт:	
<p>С.Ганзаяа: Төслийн төсвийн шинэчилсэн хураангуй дээр нэмэлтээр авах 1,5 сая ам.долларын санхүүжилтын: 500,000 ам.долларыг сүрьеэгийн оношилгоо, эмчилгээ; 1 сая ам.доллар нь бүхэлдээ эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүртээмжийг сайжруулах чиглэлээр зарцуулна. Хөтөлбөрийн менежментийн хувьд энд ямар нэг нэмэлт зардал тусгаагүй. Одоо хэрэгжиж буй төслийн төсвийн батлагдсан хураангуй тэр чигээрээ байгаа. Энд юу байгаа гэхээр, төсөл хэрэгжүүлж буй байгууллагуудын хүний нөөцийн зардал: 6 СХА болох МСЭМХ, МӨАУМХ, МСТН, МУЗН-ийн менежментийн зардлууд болон ХЗН-ийн ажилчдын цалин багтаж байна. Тэгэхээр энэ 10% бол 7,2 сая ам.долларын төслийг батлуулахад ямар хэмжээтэй байсан тэр өөрчлөгдөөгүй байгаа.</p> <p>Ханган нийлүүлэлт болон бусад зардлууд ийм бага хэмжээг эзэлж байгаа нь нэмэлт санхүүжилт 2 модуль дээр нэмэгдэж орж ирж байгаа, нийт санхүүжилтэнд орсон санхүүжилт нэмэгдэх хирээр бусад модулиуд бага харагдаж байна. Ханган нийлүүлэлтийн менежмент, ЭМ-ийн мэдээллийн тогтолцоо сайжруулах, хүний нөөцийг бэхжүүлэх гэх мэт үйл ажиллагаанууд одоо батлагдсан байгаа 7,2 сая ам.долларын төслийн гэрээн дээр энэ чигээрээ явж байгаа.</p> <ol style="list-style-type: none"> 1. Хүний нөөцийг бэхжүүлэх модулийн хүрээнд Сүрьеэгийн салбарт ажиллаж буй эмч, мэргэжилтнүүдийг сургах үйл ажиллагаа, мөн орон нутагт ажиллаж байгаа хувийн болон улсын эмнэлгүүдийн эмч нарын сургалт болон хамгийн гол нь Сүрьеэгийн салбарт ажиллаж байгаа хүний нөөцийн дутагдлыг нөхөх зорилготой резидент эмч нарын төлбөр, тэтгэмжийн асуудал энэ модулийн хүрээнд байгаа. 2. Ханган нийлүүлэлтийн менежмент гэсэн модульд-ГС төслийн хүрээнд нилээд хэдэн үнэ бүхий тоног төхөөрөмжийг ханган нийлүүлсэн. Мэдээлэл хүргэх үүднээс хэлэхэд 2018 оны төслөөр 10 ширхэг дижитал рентген аппаратыг ХӨСҮТ-д нийлүүлсэн. Мөн дээрээс нь ДЭМБ-тай хамтран ГС-ын Сүрьеэгийн төслөөр 2018 онд 6 ширхэг Жен Эксперт аппаратыг авч нийлүүлсэнээр Үндэсний хэмжээнд өнөөдрийн байдлаар нийт 20 Жен Эксперт аппарат ажиллаж байна. Тэгэхээр эдгээр үнэтэй тоног төхөөрөмжүүдийг бид даатгалд хамруулах үйл ажиллагаа энэ зардалд бас байгаа. Учир нь орон нутгийн байгууллагууд эдгээр үнэтэй тоног төхөөрөмжийг хадгалах хамгаалах үүрэг нь мөн боловч, бид тодорхой хэмжээгээр эрсдэлээс урдчилан сэргийлэх үүднээс даатгалд хамруулж байна. Мөн дээрээс нь сүрьеэгийн төслийн ханган нийлүүлэлтийн ихээхэн хувийг олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн 2-р эгнээний эм эзэлдэг. Эмийн хувьд одоогоор эмчилгээ богиносох туршилтын шатанд явж байгаа ч гэсэн орж ирсэн эмийг нилээд удаан хугацаагаар хадгалдаг. <p>П.Анузаяа мэргэжилтэнд баярлалаа. Өөрчлөлт оруулж байгаа эдгээр үзүүлэлтийг бид гаргахын тулд тодорхой хэмжээний бодолт, математик загварчлалыг ашигласан. Ерөнхийдөө одоо хэрэгжиж буй төслийн ХШҮ-ний хүрээг боловсруулахдаа гаргасан тооцоолол дээр үндэслэн хувиа нэмсэн. Тооцооллыг хийхдээ Тархалтын судалгааны дүн дээр МУ-д байх магадлалтай сүрьеэтэй өвчтөний тоог 100,000 хүн ам тутамд 428 байна гэж тогтоосон. Тэгэхээр 2019, 2020 онуудад хүн амын өсөлт хэдий хэмжээгээр өсөх эсэх тоонд харьцуулан МУ-ын хүн амын дунд байж болох сүрьеэтэй өвчтөнийхөө тоог гаргаад, тус тоон дээр үндэслээд тухайн байж болох тохиолдлоосоо 2019 онд 49%-ийг нь илрүүлбэ гээд харьцуулан тооцоход тус 6900 гэсэн тоо гарч байна. 2020 оны хувьд тухайн байж болох тохиолдлын 54%-ийг дахин илрүүлнэ гээд 7800 гэсэн тоо гарч байна. Ерөнхийдөө 100,000 хүн амд эзлэх өвчлөлийн тоог хүн амын өсөлтийн хувьтай харьцуулж үзэхэд МУ-ын нийт 3,200,000 хүн амын дунд 13,000 орчим тохиолдол байж болох тооцоолол гарч байна.</p> <p>Б.Сувд гишүүний асуултын хариулт:</p> <ol style="list-style-type: none"> а) Энэ төслийн үйл ажиллагаа 2020 он хүртэл явагдана. Ерөнхий үйл ажиллагаа юунд чиглэгдэх 	

талаар ГС-аас бидэнд ямар зөвлөмж өгч байгаа болон АХБ-ны МУ-ын ЗГ-т олгох хөнгөлөлттэй зээлийн үйл ажиллагаанд сүрьеэ, БЗДХ/ДОХ-ын үйл ажиллагааг оруулах юм. ГС-аас ирүүлсэн мэдэгдэл болон бидний хэрэгжүүлж байгаа төслөөс харахад Мобайл технологи гэдэгт бидэнд өмнө сүрьеэгийн идэвхитэй илрүүлэг/оношлогоонд техник, технологийн боломж хязгаарлагдмал байсан. Одоо энэ нөхцлийг халах зорилгоор нилээд олон тоогоор зөөврийн дижитал рентген аппарат ханган нийлүүлсэн. Тэгэхээр үзлэгийн баг маань үзлэг хийхдээ эрсдэлт бүлгийн хүн амыг үзээд, шаардлагатай тохиолдолд цэрний шинжилгээг газар дээр нь хийх болно. Гэхдээ үүнийг зөвхөн сүрьеэ бус тухайн орон нутаг өөрөө халдварт болоод халдварт бус өвчлөлийн үзлэгтэй хамтруулж явуулах үйл ажиллагааг түлхүү оруулна. Түүнчлэн ЭМ-ийн анхан болон хоёр дахь шатлалын тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах АХБ-ны төсөл дээр давхар сүрьеэ, БЗДХ/ДОХ-ын үйл ажиллагааг оруулж явах ийм үйл ажиллагаанд зарцуулна гэсэн төлөвлөгөөтэй байна.

б) Англи хэл дээр энэхүү мэдэгдэл нь *“Increase the capacity of workforce”* гэж байгааг бэхжүүлэх, сайжруулах гэж оруулсан. Энд эмэнд мэдрэг сүрьеэгийн оношилгоо, илрүүлэлтийг сайжруулах гэсэн эхний модуль дээр тавигдсан байгаа. Ерөнхийдөө эдгээр үйл ажиллагаа, чадавхи бэхжүүлэх сургалтын үйл ажиллагааг одоо хэрэгжиж буй АХБ-ны Гепатитын төслийн загварыг ашиглаад, (АХБ Гепатитын чиглэлээр үндэсний хэмжээний сургагч багш бэлтгэж байгаа ба тэд 21 аймаг, 9 дүүрэгт хүрч очоод тухайн орон нутгийн ахлагч болон 2-догч шатлалын эмч нарыг бүгдийг нь Гепатит В,С-ийн илрүүлэг, оношлогоо, эмчилгээнд сургана) энэхүү загвараар сүрьеэгийн үндэсний сургагч багш нарыг бэлтгээд тус багш нар маань 21 аймаг, 9 дүүрэгт очоод төрийн болон хувийн бүхий л эмч, мэргэжилтнүүдийг сургахад зарцуулагдах болно.

М.Сэргэлэн: Энэхүү 1,5 сая ам.долларын төсөл одоо хэлэлцээрийн түвшинд явж байгаа. Үүний 500,000 ам.доллар нь энэ жилдээ багтаж Монгол улсын бүх эрүүл мэндийн ажилтнуудын сүрьеэгийн үзлэг, оношилгоо, эмчилгээ болон сүрьеэ өвчний талаар хандуулах анхаарлыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилгоор хамтарсан мэдээлэл, мэдлэг, харилцааны үйл ажиллагаагаар дамжуулан сүрьеэгийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр зарцуулагдах нь тодорхой болчихсон. Үлдсэн санхүүжилтын хувьд АХБ-ны Гепатитын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх Засгийн Газарт олгох зээл УИХ-аар батлагдсан тохиолдолд ГС-ийн нэмэлт 1 сая ам.долларын санхүүжилт орж ирэх бөгөөд эдгээр нь хоорондоо шууд хамааралтай. Хяналт шинжилгээ үнэлгээний хувьд ГС-аас зорилтоо өөрчил гэсэн. ХШҮ хариуцсан мэргэжилтний хувьд энэ жил бидэнд зорилтыг өөрчлөх боломж байхгүй энэ талаар бид ГС-тай ярилцах болно. Учир нь энэ жилийн үйл ажиллагаа бол зөвхөн хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэгдсэн тул бид тохиолдлын хувь, тоог өөрчлөх үндэс харагдахгүй байгаа юм л даа. Бид 2018-2020 оны төслийг өргөн барихдаа зорилго, зорилтоо аль хэдийн тодорхойлоод илгээсэн. ГС-аас биднийг зорилтоо нэмэгдүүлэхийг шаардаж байгаа боловч бид өөрсдийн хэмжээнд ул үндэстэй хэлэлцээр хийх болно гэдэг талаар тодруулга өгөх гэсэн юм.

Т.Энхзаяа: ХШҮ-ний гүйцэтгэлийн хүрээ хэлэлцүүлэх хэмжээнд хүрээгүй байгаа ба үүн дээр зарим үзүүлэлтүүд холилдоод орсон байгаа. Бидний зүгээс энэ талаар ярилцаад хэлэлцүүлэх хэмжээний санал болгоод та бүхэнд танилцуулах болно. Яг энэ тал дээр бид хараахан ярилцаж амжаагүй байгаа гэдгийг хэлэх байна.

Шийдвэр:

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар

Зөвшилцөл	х			
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх	
			Нууц санал хураалт	
		Дэмжсэн>		
		Эсрэг>		

Хөтөлбөр #4

Эрсдэлт бүлгийн хүн амд чиглэсэн ХДХВ/ДОХ-ын 8 орны хамтарсан төслийн талаар мэдээлэл-Асуулт, хариулт

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Байхгүй.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (гийм эсвэл үгүй)>

үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

Д.Мягмардорж, ЗЭМ-ын гүйцэтгэх захирал: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Энэхүү Эрсдэлт бүлгийн хүн амд чиглэсэн ХДХВ/ДОХ-ын 8 орны хамтарсан төслийг МУ 2019-2021 онд хэрэгжүүлэхээр болсон. Энэ талаар товчхон мэдээлэл хийе.

- Австралийн Дохын Нэгдсэн Холбоо(АДНХ)-оос 12 сард СХА сонгон шалгаруулах үйл явцын мэдээллийг ирүүлж ҮЗЗ 12 сард үндэсний өдөр тутмын сонинд хэвлүүлсэн.
- Тус зарын дагуу манай байгууллага АДНХ-д хүсэлтээ хүргүүлсэн.
- Улмаар 2019 оны 1 сард манай байгууллага СХА-аар ажиллах боломжтой гэсэн хариуг хүлээн авсан.
- 2019 оны 2 сарын 18-19-ний өдрүүдэд АДНХ-ээс СХА-ын үнэлгээ хийгдсэн бөгөөд энэхүү үнэлгээгээр хүний нөөц, болон бусад чадавхи байгаа эсэх талаар үнэлгээ хийгдсэн. Энэ үнэлгээ нь батлагдсан СХА байгууллагыг цаашид ажиллуулах эсэхэд нөлөөлөхгүй зөвхөн тус ажлыг үргэлжлүүлэхэд тухайн байгууллагад юу дутсан, юуг сайжруулах шаардлагатай талаар зөвлөгөө дүгнэлтийг өгсөн.
- 2019 оны 2 сарын 28-ний өдөр СХА-ын гэрээг байгуулах тухай товыг бидэнд мэдэгдсэн.
- Түүнчлэн 3 сарын эхээр төслийн зохицуулагч, бүсийн зөвлөхтэй хамт 10 хоногийн хугацаатай хүрэлцэн ирж чадавхижуулах сургалтуудыг зохион байгуулна. Тухайн сургалтаар ажлын төлөвлөгөөг илүү дэлгэрүүлэн ажиллах ба МУ-д техникийн дэмжлэг үзүүлэх болон бусад үйл ажиллагааны талаар хэлэлцэнэ. Гэхдээ ҮХА-ЭМЯ энэхүү төсөлд гол хамтрагч тал байх учраас энэ байгууллагуудтай хэрхэн уялдаатай ажиллах талаар зөвлөлдөх, чиглэл өгөхөөр 10 хоногийн төлөвлөгөө гарсан.

Одоохондоо бидний хооронд гэрээ байгуулагдаагүй байгаа тул төсөв төлөвлөгөөрүү орж ярих боломжгүй байгаа.

Энэхүү төслийг бичилцэх, батлуулахад хамтран идэвхитэй оролцсон Ажлын хэсгийн гишүүд болох ҮАБЗ, ЭМЯ, ХЭҮК, ХЗН-ийн төлөөллүүдэд болон бусад ТББ-д талархал илэрхийлэхийн сацуу цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаанд бидэнд дэмжлэг, туслалцаа үзүүлэн хамтран ажиллаж төслийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд оролцоно хэмээн найдаж байгаа. Та бүхэнд баярлалаа!

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

Хариулт

Шийдвэр:**Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар**

Зөвшилцөл

x

Санал хураалт

x

Санал хураалт

Гар өргөх

(Тохирох нүдийг бөглөнө үү)	Нууц санал хураалт		
Дэмжсэн>			
Эсрэг>			
		Санал өгөхөөс түдгэлзэх	

Хөтөлбөр #5	Хяналтын тайлан <ul style="list-style-type: none"> • Улаанбаатар хот ХӨСҮТ-ийн ДОХ, Сүрьеэгийн алба, МӨАУМХ, МСЭМХ, Хүүхэд залуусыг дэмжих төв, <ul style="list-style-type: none"> • Хөдөө орон нутаг Увс, Завхан аймгуудын хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцсан ажил Асуулт, хариулт
--------------------	--

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Байхгүй.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>

үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

Улаанбаатар хотын хяналтын ажлын тайлан

- ХӨСҮТ-ийн ДОХ, Сүрьеэгийн алба, МСЭМХ-ийн танилцуулгыг **А.Цэцэгмаа, ҮЗЗ-ийн Хяналтын хорооны гишүүн** танилцууллаа;/Танилцуулгыг Хавсралт 2-оор оруулав/

Та бүхэнд дэлгэрэнгүй тайлан болон танилцуулгыг тараасан учраас аль болох нэгтгэн танилцуулья.

Ерөнхийдөө бидний очсон газар бүр өөрсдийн үйл ажиллагаагы танилцуулгыг бэлтгэж, зохих хүмүүстэй уулзуулан, асуултуудад хариулж, биднийг нааштайгаар хүлээн авч байсныг дуулгахад таатай байна. Бид ажлын даалгаврын хүрээнд байгууллагуудын үйл ажиллагаатай танилцсан бөгөөд, ямар нэгэн бичиг баримт үзэж, өрөө тасалгаагаар ороогүй болно. Тэдгээр газруудын үйл ажиллагаатай танилцаад, ололт амжилт, саад бүрхшээлийн тухай ярилцаж, зөвлөгөө өгч байсан. Газар бүрийн онцлогод тохируулан бидний зүгээс өгсөн зөвлөмжүүдийг дэлгэрэнгүй тайландаа тусгасан байгаа. Товчлох үүднээс онцлох зүйлсийг тодруулан хэлээд явья.

ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн ТСА: Гаалийн агуулахаас эмээ цаг хугацаанд авч чаддаггүй. Бичиг баримтыг яамнаас тухай бүрт нь бүрдүүлж өгдөггүй. Өөр газрын агуулахад эмээ хадгалахад их хэмжээний нэмэлт зардал гардаг. Жишээлбэл: Бид 11-р сарын 20-нд уулзсан бөгөөд, 10-р сард гааль дээр ирсэн эмийн ЭМС-ын тушаал нь гарч хуваарилагдаагүй, агуулахад хадгалагдаж байсан. Гэтэл эм тараах шаардлагатай байан тул, өөр газраас эмээ зээлдэн авч тараасан байсан. Мөн эмийн мэргэжилтэн нэг л ажилладаг тул, ажлаа дийлдэггүй. Мөн санхүүгийн ажилтнуудад төслийн санхүүгийн тайлан гаргах нэмэлт ачаалалтай байдаг боловч санхүүгийн урамшуулал байдаггүй нь хүндрэлтэй байдаг талаар хэлж байсан.

ХӨСҮТ-ийн БЗДХ-ын ТСА: Энд ч бас санхүүжилтын асуудал хоцордог талаар хэлж байсан. Ололт амжилтын хувьд эхээс урагт ХДХВ-ын халдвар дамжаагүй гэдгийг онцолсон. Харин тэмбүүгийн хувьд жирэмсэн эхээс жирэмсэний хугацаанд 2 удаа шинжилгээ авах ёстой, гэвч зарим тохиолдолд эмэгтэйчүүд шинжилгээндээ ордоггүй бол зарим үед шинжилгээнд хамрагдаад тэмбүүгүй гэж гардаг боловч хүүхдээ төрүүлээд шинжлээд үзэхэд төрөлхийн тэмбүүтэй тохиолдол гардаг талаарх асуудлуудыг дурдсан.

Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбоо (МСЭМХ): Монголын бүх аймаг, сумдуудаас сүрьеэгийн бүхий л сорьцыг тээвэрлэдэг гэх жижиг атлаа том ажил хийдэг байгууллага байсан. Ерөнхийдөө бүх аймаг, сумдаас сорьцыг тусгайлан тээвэрлэхэд зардал ихтэй учраас тусгай битүүмжлэлтэй саванд сорьцыг хийгээд замын жолоочид хийгээд явуулдаг ажээ. Тэгэхээр тээвэрлэх боломжит хугацаа, тээвэрлэлтийн чанар хангагдаж байгаа эсэх болон тухайн сорьцын үр дүнд тээвэрлэлтийн явц нөлөөлөдөг эхсэх асуудал гардаг байна.

Дүгнэлт:

ХДХВ/ДОХ, сүрьеэгийн өвчлөлийн түвшин нэмэгдэж байгаа өнөө үед тус хөтөлбөр нь МУ-ын хувьд маш чухал үүрэгтэй. МУ-ын ЗГ-аас эдгээр өвчнүүдийн талаар зохих арга хэмжээг авч санхүүжилтыг гаргадаг боловч Олон эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөний эмийн 80%-ийг ГС-аас хүлээн авдаг бөгөөд магадгүй үлдсэн 20%-ийн санхүүжилтыг өөр ямар нэг ОУ-ын байгууллагаас авдаг байх. Тиймээс эдгээр үйл ажиллагааг төсөл дууссаны дараа тогтвортой үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд МУ-ын ЗГ-аас тодорхой анхаарал тавих ёстой. Төсөл хэрэгжүүлэх нэгж, Эрүүл мэндийн яамнаас төслийг хэрэгжүүлж байгаа салбар нэгжүүдэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх, хамтран ажиллах асуудал дутагдалтай байна гэж харагдаж байсан.

Төслийн үйл ажиллагаа нь тухайн байгууллагын үйл ажиллагааны салшгүй нэг болон болж ажиллаж байгаа нь олзуурхууштай боловч, яг төслийн үр дүн ямар байгаа, ямар хэмжээний зарцуулалт хийхээс хэдийн хэмжээний хөрөнгө зарцуулсан мэдээлэл байхгүй, зардлыг хэрхэн үр дүнтэй зарцуулж байгааг хянадаггүй, дутагдалтай байсан. Төсөл тусдаа санхүүгийн тайлан гаргахыг шаарддаг учир энэ тал дээр тодорхой хэмжээний урамшуулал өгч ажиллуулахгүй бол нэмэлт ачаалал болдог. Мөн төслийн хүрээнд олон тоног төхөөрөмж авч өгсөн боловч зарим нь эвдэрсэний улмаас ашиглагддаггүй. Хэрхэн засуулах талаар мэддэггүй, засварын зардлыг хаанаас гаргуулахаа мэддэггүй байна. Тиймээс дээрх асуудлуудад ХЗН анхаарал тавьж ажиллах хэрэгтэй.

-Санхүүжилттэй холбоотой тушаал шийдвэрүүдийг цаг тухайд нь гаргадаггүйгээс хөтөлбөрийн үйл ажиллагаа хоцрох, жилийн төлөвлөгөө тасрах эрсдэлүүд тулгардаг асуудлуудыг ЭМЯ болон ХЗН анхааран ажиллах шаардлагатай гэсэн зөвлөмж өгч байна

-Түүнчлэн эргэх холбоог сайжруулан тухайн байгууллагууд дээр тогтмол очиж, туслах, зөвлөгөө өгөх, байдлаар хамтран ажиллах нь илүү дүнтэй байх болно.

-Миний хувьд ҮЗЗ-д 1,5 жилийн хугацаанд ажиллахдаа анх удаа ийм танилцах айлчлалаар явсан. Ерөнхийдөө ҮЗЗ-ийн гишүүдийг СХА-даар явуулж үзүүлэх хэрэгцээтэй юм гэсэн дүгнэлтэнд хүрсэн. Тэгэхдээ ажлын удирдамжийг илүү тодорхой болгох хэрэгтэй гэж санагдсан.

➤ **МӨАУМХ, Хүүхэд залуусыг дэмжих төвийн танилцуулгыг - С.Энхжин, ҮЗЗ-ийн Хяналтын хорооны гишүүн танилцууллаа. /Танилцуулгыг Хавсралт 3-аар оруулав/**

А.Цэцэгмаа гишүүний хэлсэнчлэн Ажлын нэгдсэн удирдамжийг сайтар боловсруулан ашиглавал энэхүү ажлын үр дүн илүү тодорхой гарах боломжтой харагдаж байсныг хэлэхийг хүсэж байна.

Бидний ажлын хүрээнд тухайн байгууллагын ажилчдын санал хүсэлтийг сонсоход илүү анхаарч ажилласан.

Монголын Өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо (МӨАУМХ): ГС-ийн дэмжлэгтэй төслийн хүрээнд ӨЭМТ-үүдэд сүрьеэгийн тусламж үйлчилгээг нэвтрүүлэн, диспансерийн ачаалалыг бууруулан, тусламж үйлчилгээг иргэдэд ойртуулан, чирэгдлийг багасгах, илрүүлэлтийг нэмэгдүүлэн өвчлөл тархалтыг бууруулах зорилго тавин ажиллаж байна.

-Аймаг, Дүүргийн ЗДТГ, ЭМГ, НЭ, ЭМТ, диспансер, баг, хорооны засаг дарга, ӨЭМТ төрийн болон ТББ хамтран сүрьеэгийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал, тулгамдсан асуудал шийдвэрлэх арга замын талаар 2 жил тутам нийт 54 удаагийн зөвлөлдөх уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулж тодорхой асуудлуудыг шийдвэрлэх талаар зөвлөмж гарган хэрэгжүүлж ирсэн нь үр дүнтэй байгаа бөгөөд аймаг, дүүргүүдийн шийдвэр гаргагчдын идэвхи оролцоо сайжирч дэмжлэг үзүүлэх байдал нэмэгдсэн.

Саад бэрхшээл: Төр засгаас дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж, Эрүүл мэндийн даатгалын сангаас ӨЭМТ-ийн нэг иргэний санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авах шаардлага үүссэн байна.

Санал

- Цаашид ӨЭМТ-үүдийн хүний нөөцийг тогтвортой болгох (жил бүр хүний нөөцийн 40% солигддог нь ажлын үр дүнг бууруулахад хүргэдэг).

- ӨЭМТ-үүдийн эмч, мэргэжилтнүүдийг үр дүнтэй ажиллуулахад хөшүүрэг шаардлагатай байна.
- ӨЭМТ болон диспансерийн уялдаа холбоог сайжруулах зорилгоор эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах давтан сургалтад хамруулах.
- Хүн амд хийж байгаа мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх.
- Орон гэргүй, ажилгүй иргэдийг нийгмийн халамж, үйлчилгээнд хамруулах.

Монголын Хүүхэд, өсвөр үеийг ивээх төв: Монголын хүүхэд өсвөр үеийг ивээх төв нь 2005 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах зорилгоор байгуулагдсан. Улмаар 2008 оноос Глобал сангийн дэмжлэгтэй төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төслийн хүрээнд хөдөө орон нутаг болон, нийслэлийн хүүхэд залуусд сургалт сурталчилгаа хийж, бэлгийн эрүүл мэндийн боловсролын талаар ойлголт мэдээллийг өгдөг. Сургалтын явцад гарын авлага, ном, танилцуулга болон тухайн хүүхдүүдийн хөгжлийн онцлогт тохирсон хараагүй хүүхдийн ном, дүлий хүүхдүүдэд дохионы хэлээр тайлбарласан бичлэгтэй CD, оюуны бэрхшээлтэй хүүхдүүдэд танилцуулга ном зэргийг тусгайлан бэлтгэж хүргэсээр байна. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох, зан үйлийг өөрчлөх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг идэвхтэй зохион байгуулдаг. “Нүдээ нээ”, “Ид шидийн орон” зэрэг сургалтыг зохион байгуулсны дараа сургалтад хамрагдсан хүмүүсээс сургалтад ашигласан гарын авлага, материалуудыг авч ашиглан өөрийн орон нутагт сургалтыг бие даан зохион байгуулах хүсэлт гаргадаг.

Саад бэрхшээл:

- Үйл ажиллагааг хэрэгжүүлэх санхүүжилт авах хүсэлт илгээхэд цаг хугацааны хувьд удаашралтай байдаг тул төлөвлөсөн үйл ажиллагааг хугацаандаа хэрэгжүүлэхэд бэрхшээл тулгардаг.
- Төрийн байгууллагуудын мэргэжилтнүүд байнга солигддог нь ажлын явцад хүндрэл учруулдаг.
- Өсвөр үеийн хүүхдүүдийн оролцоо идэвхи сайн боловч их сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутнууд идэвхи султай оролцдог.

Бидний хувьд очсон байгууллагууддаа зөвлөмжүүдийг цаг тухайд нь өгөөд явсан.

Хөдөө орон нутгийн хяналтын ажлын тайлан

➤ Увс, Завхан аймгуудын хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцсан ажлын тайланг **Ц.Адьяахишиг, ҮЗЗ-ийн гишүүн** танилцууллаа. */Танилцуулгыг Хавсралт 4-т оруулав./*

Танилцах ажлын материалыг та бүхэнд тараасан бөгөөд гарсан саад бэрхшээлүүдийн хувьд өмнөх 2 танилцуулгатай ижил төстэй зүйлс ихээхэн байсан тул та бүхэнд шууд дүгнэлтийг ярих нь үр дүнтэй санагдлаа.

Нэгдсэн дүгнэлт:

СҮРЬЕЭ

- Увс аймагт-өндөр үнэтэй тоног төхөөрөмжийн хадгалалт хамгаалалт маш муу байгаа тул сайжруулах (зөөврийн дижитал рентген аппарат);
- Өндөр үнэтэй тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, үзлэгийг тогтмолжуулах;
- Эмийн хадгалалт, хамгаалалт муу, зориулалтын бус байранд хадгалж байгааг Эрүүл мэндийн нэгдлийн эмийн агуулахад хадгалах;
- Сумын эмнэлгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах ;
- **Завхан аймгийн** Сүрьеэгийн диспансерт халдвар хамгааллын дэглэм алдагдсаныг яаралтай засаж өөрчлөх;
- 2011 онд Глобал сангаас лабораторийн ширээ сандал ханган нийлүүлэгдсэн боловч ширээг одоо хүртэл угсраагүй, эрэг боолт нь дутсан, тухайн үед задгайгаар нь хүлээн авсан. Буцаах, солиулах хүсэлт гаргаагүй.
- Сүрьеэгийн диспансерийн өрөө тасалгааны хүрэлцээ муу. Сүрьеэтэй өвчтөний эм уух өрөөнд ДОХ, БЗДХ-ийн кабинетыг байрлуулсан. Сүрьеэгийн тасаг, лаборатори, эм олгох зэрэг өрөөнүүд бүгд нэг дор, агаарын урсгал муу, халдвар хяналтын тогтолцоо алдагдсан.
- Сүрьеэгийн эмийг нэгдсэн эмнэлгийн эмийн агуулахад хадгалдаггүй. Шаардлага хангахгүй, зориулалтын бус өрөөнд хадгалж байлаа.

- Мөн ажиллах хүч дутагдалтай. Нэг эмч-бага эмч, дүн бүртгэгч, эмийн сувилагч, диспансерийн эмч, тасгийн эмч зэргийг нэг дор хийдэг.
- Сүрьеэгийн тасаг, диспансер механик агааржуулалтын систем байхгүй;
- ЭМБ эмч, ажилтны ажиллах орчин нөхцөлд бүрдүүлэх;
- Хүний нөөцийн асуудалд онцгой анхаарах;
- Зөөврийн дижитал рентген аппаратыг өнгөрөгч оны 11-р сард аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүлээлгэн өгсөн. Аппаратыг хүлээн авсан цагаас хойш ашиглаагүй, цөмийн энергийн газраас ашиглах тусгай зөвшөөрөл 2019 оны 1-р сарын сүүлээр гарах тооцоололтой. Рентген аппаратан дээр ажиллах нийт 3 хүнийг ХӨСҮТ дээр төслийн шугамаар сургасан ч нэг нь сургалтанд хамрагдсаны дараа тэтгэвэртээ гарсан, дараагийн хүн амаржсаны чөлөөтэй, одоогоор сургалтанд хамрагдсан рентгений техникч тогтвортой ажиллаж байгаа нь удирдлага зохион байгуулалт, бодлого байхгүй байгааг харуулж байлаа.

БЗДХ/ХДХВ/ДОХ

- БЗДХ-ын эрт илрүүлэг хангалтгүй, үзлэг шинжилгээ сайжруулах тогтмол авч байх;
- Эрт илрүүлэг үзлэг хангалтгүй. ЭМС-ын 2017 оны 305 тушаалаар батлагдсан журмууд хэрэгждэггүй;
- Шинжилгээний дээж зөөвөрлөх горим алдагдсан, сорьцын чанар алдах, шинжилгээний хариу буруу гарах эрсдэл өндөр;
- Эрсдэлт бүлэгт чиглэсэн үйл ажиллагаанд ТББ-дын оролцоо байхгүй;
- Өвчтөний эрүүл мэндийн нууцын хадгалалт хамгаалалт сул, нууц задрах эрсдэл өндөр;
- Мэргэжлийн эмч байхгүй, АШУИС болон хувийн их дээд сургуулиар бэлтгэгдсэн эмч мэргэжилтний мэдлэг чадвар муу, эмч нарын давтан сургалтын чанарт анхаарах;
- Эмч, эмнэлгийн ажилтнуудыг хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголт нэмэгдүүлэх, хүний эрхэд суурилсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, хүний эрхийн сургалтад бүрэн хамруулах.

Хяналтын хороонд:

- Төсөл хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах ажлын удирдамжийг эргэн хянах, боловсронгуй болгох.
- ЭМ-ийн тусламж үйлчилгээг анхан шатанд үзүүлж байгаа сум, өрх дээр ажиллах хэрэгтэй гэсэн саналыг дэвшүүлж байна.

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

ТБ	<p>Ж.Мөнхжаргал: 1. 1,2-р багаас асуух асуулт–МСЭМХ-ийн сорьц тээвэрлэлтийн талаар УБ-д хэрэгждэг эсэх талаар мэдээлэл өгнө үү.</p> <p>2. Т.Энхзаяа даргаас асуухад 7 сард гарсан нууцын зэрэглэлтэй ноцтой асуудалтай холбоотойгоор аймгийн түвшинд ажил сайжирч байгаа эсэхийг үзэхээр Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж очиж үзсэн. Тэгэхэд цар хүрээгээрээ ЭМЯ-ны ажилчдын хувьд ч, аймгийн хувьд ч унасан. Энэ хүрээнд ЭМЯ-наас авч хэрэгжүүлж байгаа ажил байна уу?</p> <p>3. Эдгээр танилцуулгуудыг сонсож байхад санхүүжилтын асуудал яг давхцаж байна. ЭМЯ-тай хамтран шийдвэрлэдэг бүхий л асуудлууд дээр дандаа зовиур, шалтаг хэлээд байх юм. Үүнийг зогсоох хэрэгтэй. Бид ҮЗЗ-ийн гишүүдийн хувьд ЭМЯ-ны ТЗУГ-ын даргыг эдгээр асуудлуудыг шийдвэрлэх байх гээд дараа нь таныг болон ХШҮДАГ-ын мэргэжилтэнг ҮЗЗ, Хяналтын хороонд оруулж ирсэн. ЭМЯ-аас ҮЗЗ-д байсан байгаагүй ГС-ийн энэхүү төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хянах, ҮЗЗ-д эргэн танилцуулах, хамтран ажиллах заалттай шүү дээ. ЭМЯ-ны төлөөллийг ҮЗЗ өөрийн удирдлагад татан оруулж ирж байхад яагаад энэ санхүүжилтын асуудлыг гацааж, гааль дээр эм, эмийн бүтээгдэхүүнийг тоос татгал нь байлгаад байдаг юм бэ? Аппарат, тоног төхөөрөмжийг нь өгдөггүй байлгаад байдаг юм бэ? Энд төсөл хэрэгжүүлэгчид зовоод байгаа бус үүнийг хүртэх иргэд эмчилгээ оношлогоо, эрт илрүүлэгт ороход 1 сарын ч атугай өмнө очиж байвал бид нэг хүн ч болтугай эрт илрүүлнэ шүү дээ. Энэ дээр та бүхэн ҮЗЗ-д нэг хариулт өгөөч.</p>
МСТН	<p>Ц.Даваасүрэн: Би 1 дүгээр багаас асуусан асуултад хариулья. Бидний хувьд байгууллагуудын удирдлагуудтай ярилцах байдлаар ажилласан. Ерөнхийдөө бүх сумдаас аймгийн төврүү сорьцыг тээвэрлэдэг түүнчлэн аймгийн төвөөс УБ хотруу сорьцыг тээвэрлэдэг 2 үндсэн үйл ажиллагааг МСЭМХ хэрэгжүүлдэг ажээ. Сумаас аймгийн төврүү сорьцыг зөөвөрлөж байгаа сорьц тээвэрлэгч</p>

	<p>нь зориулалтын саванд хийгээд зарим тохиолдолд замын унаанд дайн хүргүүлдэг юм байна. Сорьц тээвэрлэлтийн замын зардлыг тухайн сумын төврүү шилжүүлдэг бөгөөд тэрхүү санхүүжилт нь гүйцэтгэлийн дараа шилжин ирдэг гэх мэт дутагдал байдаг. Аймгийн төвөөс УБ хотруу шилжүүлж байгаа тохиолдолд тухайн аймгийн ЭМГ-руу төрийн сангаас шилжүүлдэг. Тус санхүүжилт яг зөөвөрлөсөн хүндээ очих хугацаа нь бас хойшилдог.</p> <p><i>ХӨСҮТ дээр очиход ч ийн санхүүжилт хойшилсонтой холбоотой асуудлуудыг нилээд дурдаж байсан. Учир нь агуулахад байгаа эмээ ЭМЯ-ны тушаал гараагүй байгаа тул өвчтөнд өгч болохгүй байсан ба ЭМ-Импексээс зээлээр авч хэрэглэж байсан тохиолдол гарсан байсан. Тэгэхээр эдгээр байнгын яригддаг асуудлуудыг УХА-ЭМЯ хурдан шуурхай шийдвэрлэж байх хэрэгтэй.</i></p> <p><i>Сорьц тээвэрлэлтийн асуудал дээр ч бас зардлыг нь тээвэрлэсэн хүнд нь шилжүүлдэг байх шаардлагатай байгаа тал дээр анхаарах хэрэгтэй.</i></p>
ЭМЯ	<p>Т.Энхзаяа: Зөв зүйтэй асуудлуудыг дурдсан байна. Зарим зүйл дээр санаа зовж байна.</p> <p>-Эм оношлуур ханган нийлүүлэлтийн тушаал шийдвэр дээр тайлбар хийхийг хүсэж байна. Энэ үнэхээр ЭМЯ-ны буруутай үйл ажиллагаанаас болж энэ асуудал үүссэн. ЭМС-д буруу ташаа мэдээлэл хүрсэнээр тус тушаал удахад хүрсэнд уучлал хүсье.</p> <p>- 2017 онд гарсан 305-р тушаалын хэрэгжилтэнд ЭМЯ-ны үр дүнг тооцох дотоод аудит, мониторингийн үнэлгээ хийнэ. Тус үнэлгээний хүрээнд тушаалын хэрэгжилт ямар гарсанг ҮЗЗ-ийн дараагийн хурлаар танилцуулах бодолтой байна.</p> <p>-Өөрийн саналыг хэлэхэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн Хяналтын багынханд маш их баярлалаа. Бидний үйл ажиллагаанд гарч байгаа алдаа дутагдлуудыг үнэхээр сайн олж харсан байна. Тэгэхээр энэ 2019 онд бид БЗДХ, сүрьеэгийн асуудлаар нилээд дорвитой үйл ажиллагааг хэрэгжүүлэх болно. Одоохондоо ЭМЯ-ны асуудал хариуцсан мэргэжилтэн өвчтэй байгаа, түүнийг ажилдаа эргэн орсон дараа нилээд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллана. Дараагийн хурал дээр Хяналтын хорооны гишүүдийн гаргасан асуудлуудад нэг бүрчлэн анхаарал хандуулан ажиллаад эргэн мэдээллэх болно гэдгээ хариуцлагатайгаар мэдэгдэж байна.</p>
АШУУИС	<p>Р.Оюунгэрэл: УБ хотын өрхийн эмнэлгүүд дээр сорьц тээвэрлэх асуудал байдаггүй боловч бэлэн байдалд байх үүднээс цэрний саваа авдаг. Учир нь төвлөрсөн газар байдаг тул сэжиглэж байгаа тохиолдолдоо бичиг өгч, харъяа нэгдсэн эмнэлгүүдгээ явуулдаг. МӨАУМХ-ын үндсэн үйл ажиллагаа бол засаг захиргааны багтай хэрхэн хамтран ажиллах үйл ажиллагаан дээр ярилцаж танилцсан.</p> <p>-Дашрамд дурдахад “Хүүхэд өсвөр үеийг ивээх төв” ТББ яг боловсролын сургууль төгссөн мэргэжилтэнтэй, хүүхдүүдэд маш тохиромжтой гарын авлага бэлтгэсэн байсан боловч санхүүжилт бага байдгийн улмаас олон тоогоор хэвлээгүй байсан. Тэдгээрийг он дамжин хэвлэгдэж байхад их үр дүнтэй байх боломжтой санагдсан. Тус байгууллагаас харахад МСЭМХ, МӨАУМХ зэрэг нь үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ эмч, мэргэжилтнийхээ үүднээс ханддаг болохоос сурган заах, олон насны бүлгийн хүүхдүүдийг хамруулах тал дээрээ дутуу харагдаж байсан. Тиймээс тэдгээр нийгэмлэгүүдийн хамтын ажиллагааг уялдуулах хэрэгтэй харагдсан.</p> <p>-Халдварын сэргийлэлт хяналтын АХБ-ны маш том төсөл хэрэгжсэн бөгөөд бүх төрлийн ЭМС-ын тушаал, журмууд байгаа тэгэхээр бид одоо хэрэгжилтийг хангах шатруу орох цаг болсон гэж үзэж байна.</p> <p>Цаашид Өрхийн эмнэлэг очиж үзэх хүсэлтэй байгаа гэхдээ Эмнэлгийн тусламж үйлчилгээний нэгжүүд дээр бүх төрлийн хяналтууд тавигддаг. Би 30 жил энэ салбарт ажиллаж байна, бид маш их хянаж шалгаад л байна гэхдээ үр дүн нь бахь байдгаараа л байна. 10 жилийн өмнөх АХБ-ны Халдварын сэргийлэлтийн төслийн хүрээнд энэ талын үйл ажиллагаа аль хэдийн сайжирсан л байх учиртай. Тэгэхээр бид бодох цаг болжээ.</p>
ТББ	<p>Б.Сувд: Маш үнэтэй тоног төхөөрөмжийг тус аймагт өгөхөд ашиглалт хамгаалалт муу байсан гээд байх юм. Гэтэл тэр аймагт сүрьеэгийн тохиолдол нь бага байсан юм биш байгаадаа? Түүнчлэн мэргэжлийн бус эмчийг сүрьеэгийн эмчийг тавиад байна гэхээр тэр аймагт тэр бас асуудал биш байсан юм биш үү? Тиймээс ханган нийлүүлэлтийг буруу хийсэн юм болов уу? Тэр талаас нь харсан зүйл байгаа юу?</p>
ХЭҮК	<p>Ц.Адъяахишиг: Увс аймагт Сүрьеэгийн өвчлөл 2018 оны байдлаар сумын хэмжээнд 13, аймгийн хэмжээнд 39 шинэ тохиолдол бүртгэгдсэн. Завхан аймгийн хэмжээнд 14 шинэ тохиолдол бүртгэгдсэн. Бусад аймгуудтай харьцуулах талаар мэдэхгүй учир нь би 2 аймагт ажилласан. Зөөврийн рентген аппаратыг хүнийг оношлох хүрээнд ашиглалтын явцыг анхаарч ажиллах хэрэгтэй. Увс аймгийн хувьд хүний эрхийн хувьд ч их анхаарал татсан. Энэ аймагт өсвөр насны хүүхдийн бэлгийн хүчирхийлэл өндөр байдаг, 6 сумаар Тува улстай хиллэдэг хөдөлгөөнт хүн ам ихтэй гэх мэт онцлогтой тул ЭМ-ийн тусламж</p>

	үйлчилгээний хүрээнд үйл ажиллагааг сайжруулах хэрэгтэй. Дээрээс нь эмийн хадгалалт хамгаалалт алдагдсан байсан.
ХЗН	С.Ганзаяа: Сүрьеэгийн өвчлөлийн хувьд баруун аймгуудруугаа буюу Увс, Завхан аймгууд өвчлөл багатай аймгуудын тоонд ордог. Тоног төхөөрөмжийн хувьд тухайн байгууллагын өөриймсөг байдал төсөл хэрэгжүүлэх явдал нилээд тулгардаг. Бид зөвхөн байхгүй байгаа нөөцийг бий болгохоор санхүүжүүлдэг. Түүнийг цаашид тогвортой авч явах, эзэмших тал дээр тухайн байгууллага анхаарч байгаасай гэж боддог. Энэ асуудлаар 11 сард болсон Сүрьеэгийн чинлэлийн дээд хэмжээний уулзалтаар нилээд дэлгэрэнгүй ярьсан. ХӨСҮТ-ээс энэ талаар албан бичиг хүргүүлнэ гэсэн.
ТББ	С.Дондов: 1. С.Энхжингээс асуухад, ӨЭМТ-үүдийн хүний нөөцийн 40% солигддог нь ажлын үр дүнг бууруулахад хүргэдэг гэсэн. Үүний шалтгаан юу байсан юм бол? 2. Ц.Адъяахишигээс асуухад, Хүний эрх зөрчигдөж нууц алдагдах магадал өндөр байгаа талаар ярилаа. Энэ талаар тухайлсан байгууллага сургалт, сурталчилгаа явуулж байгаа зүйл байгаа юу?
ЭМЯ	С.Энхжин: Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо /МӨАУМХ/ нь Монгол улсын “Төрийн бус байгууллагын тухай” хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцсэн үйл ажиллагаа явуулдаг, ашгийн төлөө бус, гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага юм. Төрөөс санхүүжилт авдаг. ӨЭМТ-үүдийн хүний нөөцийн 40% солигддог нь залуу ажиллах хүчин ажилладаг нь төгсөлтийн дараах сургалтын чиглэлд 2 жил өрх, сумын ЭМ-ийн төвд ажилласны дараа мэргэшүүлэх сургалтанд хамрагдах заалттай. Үүний дагуу ӨЭМТ-д 2 жил ажиллаад мэргэшүүлэх сургалтанд хамрагдаад, тэр чигээрээ буцаж ирэхгүй тохиолдлууд их гардаг нь нөлөөлдөг.
ХЭҮК	Ц.Адъяахишиг: Хүний эрхийн байгууллагаас ЭМБ-ын ажилтнуудад зориулсан хүний эрхийн талаарх сургалтыг тэр бүр хийгээгүй. Энд би 2017 онд хэвлэгдэн гарсан “Хүний эрх ба ЭМ-ийн тусламж үйлчилгээ” гэдэг номыг авч ирсэн. Бид ЭМБ-руу хандах шаардлага үүссэн байгааг олж харсан учир нь ХЭҮК улсын хэмжээнд 10-12 аймагт ажилладаг ба ажиллах явцад ЭМ-ийн тусламж үйлчилгээний чанар дээр ЭМБ-ын ажилтнуудын ёс зүйн асуудал байнга яригддаг. Түүнчлэн ЭМ-ийн нууцлалын асуудал хөндөгддөг. Өнөөдөр сумынхаа ЭМТ-д үзүүлэхгүй гэж маш олон газрын иргэд хэлдэг. Учир нь ямар нэг байдлаар БЗДХ илрэхэд тэр сум даяар мэдээлэл задардаг. Түүнээс үүдэлтэй гэр бүл салалт гэх мэт маш олон асуудлууд бидний шалгалтын хүрээнд ажиглагддаг. Төсөл хөтөлбөрийн хүрээнд ч Хүний эрхийн сургалтын талаар СХА-ууд анхаарахыг хүсэж байна. Энэ сургалтыг хийх ХЭҮК-ийн 21 аймагт байрладаг ажилтнууд бүгдээрээ чадавхижсан. Үүнээс гадна энэ сургалт цахим хэлбэрээр явдаг. Өнгөрсөн оноос эхлээд ЭМ-ийн төвтэй хамтран энэхүү сургалтын гарын авлагыг магадлан итгэмжлүүлдэг цахим сургалтыг явуулсан. Харамсалтай нь цахим сургалтанд хамрагдалт маш бага байна. Гэхдээ энэ сургалтыг Завхан аймгийн ЭМН-д явуулаад хагас жилийн дараа очиход бахь байдгаараа л байгаа болохоор ганц удаа хэлэх бус олон дахин бүх л салбараар, өөр өөрийн түвшинд нь хүний эрхийн асуудлыг таниулах хэрэгтэй байна.
ХОН	Н.Туяацэцэг: 1.Төслөөр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг яагаад өдий хүртэл ашиглахгүй, эрэг боолт дутуу асуудлыг хүлээн авсан байгууллага нь шийдвэрлэж чадахгүй байгаа юм бэ? 2. Цаашид төслийн хүрээнд дахин тоног төхөөрөмж шаардлагатай шазарт нь олгоход засвар арчлалт, хамгаалалтыг хэн хариуцаж үр дүнтэй ажиллуулахад нь анхаарал тавьж ажиллах вэ? 3. Нэн шаардлагатай байгаа аймаг сумдад тоног төхөөрөмжийг шилжүүлж болдоггүй юм уу? 4. Төслөөр нийлүүлэгдэж байгаа тоног төхөөрөмжийг үр ашиггүй, тоосонд даруулж байлгадааргүй байна.
ҮХА-ЭМЯ	Т.Энхзаяа: Өнгөрсөн долоо хоногт ЭМ-ийн удирдах ажилтнуудын зөвлөгөөн болсон. Тус зөвлөгөөн дээр НЭМГ 4 ажлыг анхааруулж, орон нутгийн ЭМГ-ын дарга нарт

	<p>тодорхой үүрэг даалгавар өгсөн. Үүний нэг нь дижитал рентген аппаратын ашиглалт хадгалалт, хамгаалалтын асуудал байсан. Би одоо ХӨСҮТ-ийн СТА-тай хамтран тэдгээр тоног төхөөрөмжийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт дээр нилээд хяналт тавьж ажиллана. Түүнчлэн ашиглалт дээр энэ жил түлхүүр хүн амд хэр хүрч ажилласан талаар дүгнэлт гаргана. Тиймээс энэ талаарх мэдээллийг болон эдгээр зөвлөмжүүд тус бүрээр хийгдсэн ажлаа ҮЗЗ-д 6-7 сард танилцуулах болно.</p>
АШУИС	<p>Р.Оюунгэрэл: Өвчин эмгэг эрт илрүүлгийн талаар л яриад байна. Гэхдээ ЕБС дээр охидын үзлэг явагддаг уу? Энэ нь хүний эрхийг хангаж чадаж байна уу?</p>
УХА-ЭМЯ	<p>Т.Энхзаяа:НҮБХАС-аас 14 аймагт өсвөр үеийн кабинет байгуулсан. Энэ жил нэмэлтээр 8 аймагт байгуулна. Тушаал журмуудын хэрэгжилтэд хяналт тавьж, ард түмэнд өгөх мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэн ажиллана. Энэ жил ХӨСҮТ-тэй хамтран хийх ажилд бүх ЕБС-ийг эрт илрүүлэн, үзлэгт хамруулах болно. Түүнчлэн үзлэг шинжилгээ болон ЕБС-ийн эмч нарыг чадавхижуулах ажлыг зохион байгуулан тодорхой ахиц гарахад эргээд мэдээлэх болно. Охидын үзлэгийн зөвлөмж гарсан байгаа бөгөөд эцэг эхийн зөвшөөрлөөр хийх болно.</p>
ХЭҮК	<p>Ц.Адъяахишиг: Охидын үзлэгийг дагуулсан асуудал их гардаг. Охид гэсэн нэрийн дор хийж буй нэр томъёоноос нь авахуулаад өөрчлөлтийг хийх хэрэгтэй. Дээрээс нь энэ үзлэгийн хийж байгаа эмч, багш нар бас л хувь хүний ЭМ-ийн нууцтай холбоотой асуудал хөндөгдөж байгаа.</p>
ТБ	<p>Ж.Мөнхжаргал: Сорьц тээвэрлэх үйл ажиллагааг ганцхан ТББ хийгээд байна. ЭМЯ хэрэгжүүлж эхлэх хэрэгтэй байна.</p> <p>-Сүрьеэгийн мэргэшүүлэх сургалтыг ҮЗЗ зүтгүүлэн ГС-ийн дэмжлэгээр хийж байна. Гэтэл энэ мэргэшүүлэх сургалтанд хамрагдалт, ирц, багш зааж байгаа байдал дээр асуудал гараад байна. Тандалт хийх хэрэгтэй байна. Жирэмсэний амралтаараа ирж сураад үнэмлэхээ аваад очоод ажлаа хийхгүй байгаа тохиолдол байгаа. Тэгэхээр энэ богино хугацааны сургалтанд сургасан шиг сургах хэрэгтэй. Бид саш олон эрхзүйн зохицуулалтыг зөрчиж байж энэ богиносгосон сургалтыг явуулж байхад итгэл алдуулсан зүйл өрнөөд байна. Дараа нь эмч өөрөө алдаа гаргахад хууль зүйн хариуцлага хүлээдэг. Тиймээс нэгэнт ийм шийдвэр гаргасан бол хяналт тавьж хурлаар хэлэлцмээр байна. Энэ сургалтанд хэн хэн сонгогдож хамрагдах болсон түүний ирц болон хэн юуг, яаж зааж байгааг сайтар хянаж байх саналтай байна.</p> <p>-Түүнчлэн ажлын хэсгийн танилцуулгын саналтай холбоотой ГС-ийн тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэлттэй холбоотой хаана, хэн, юу ажиллуулж байгаа талаар мэдээлэл өгнө үү. Би өөрөө оношлогооны эмч, гэтэл төхөөрөмжийг ажиллуулах явцдаа авсан зургыг нь харахад ч шаардлага хангахгүй байсан. Эмч мэргэжилтэн зургаа буруу авч, тоног төхөөрөмжийнхээ гаралтыг тохируулж чадахгүй ясны зураг аваад тавьсан байсан. Тэдгээр зургуудыг харахад ямар ч чадамжгүй байсан ба бид ирсэний дараа 2 яамны ТНБД- д нууцын зэрэглэлтэй асуудлуудыг танилцуулсан. ЭМЯ-ны бодлогын алдаа, явцын хяналт дээр ҮЗЗ орж байгаа. Тиймээс ЭМЯ зургуудаас үзээд хяналтаа тавих хэрэгтэй байна. Бид өндөр хэмжээний санхүүжилтээр тоног төхөөрөмж ханган нийлүүлж байхад зургаа авч чадахгүй байгаа энэ асуудлаа ҮЗЗ-д дахин танилцуулна уу.</p>
ТБ	<p>М.Зэндмаа: Ажлын хэсгийн хийсэн танилцуулгаас дүгнээд зөвлөмжүүдийг холбогдох газруудад өгөх ёстой байх. Тэгэхээр нэгдсэн удирдамж байгаагүйгээс зөвлөмж янз бүр гарах шинжтэй байна. СХА-уудад хяналт тавихад тухайн байгууллагын гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж, тавьсан зорилтдоо хүрч чадаж байгаа эсэхд анхаарах шаардлагатай. Үнэхээр баруун бүсийн аймаг өвчлөл багатай бол зөөврийн аппаратыг яагаад тэнд нийлүүлсэн юм бэ? Өвчлөл ихтэй газраа өгөх хэрэгтэй байсан юм биш үү. Дараа дараагийн газруудад хуваарилалтыг хийхдээ өвчлөлийн түвшинг харах хэрэгтэй. Жишээ нь: УБ хотод ганц зөөврийн рентген байхад бид 14,14 хоног дүүргүүддээ өгөөд үзлэг, оношлогоогоо хийгээд явж байсан. Тэгвэл тэр хэрэггүй газарт байгаа тоног төхөөрөмжийг шилжүүлж өгөөч ээ. Ялангуяа УБ-т үнэхээр их хэрэгтэй байна. Хамгийн их өвчлөлтэй газраа дахин хуваарилалтыг боломжтой бол хийх хэрэгтэй гэсэн</p>

хүсэлтийг тавьж байна.

- Нэмэлт 1,5 сая ам.долларын санхүүжилтыг шалгуур үзүүлэлт дээр анхаарахыг хүсэж байна. Хэт өндөр зорилт тавьбал гүйцэтгэлээр авч байгаа санхүүжилтэнд нөлөөлөх эрсдэлтэй. Тухайлбал 2017 оны үзлэг илрүүлэг хийсэн боловч өвчлөл бага илэрсэн. Тэгэхээр баримжаа үзүүлэлтээр тоон үзүүлэлтийг тавих нь зөв эсэхийг бүгдээрээ сайтар ярилцаж шалгуураа тогтоогоосой гэж хүсэж байна.

-Нийслэлийн ЕБС-д үзлэг оношлогоог хийхдээ хамар, залгиур хоолойн үзлэгийг хийдэг. Сүрьеэгийн үзлэгийг бол их хийдэг. Ялангуяа сүрьеэ илэрсэн сургуулиудад, энэ жил 70-д газарт үзлэг зохион байгуулахаар Боловсролын Газарт бичгийг хүргүүлсэн. БЗДХ-ийн хувьд хүний эрхийн асуудал хөндөгддөг учир үзлэгт та заавал ор гэж шаардаж чадахгүй байна. Тэгэхээр сайн дурын үндсэн дээр энэхүү үзлэгийн зохион байгуулдаг.

МҮЭ **Б.Мягмар:** Эдгээр танилцах айлчлалын мэдээллийг харж байхад байнга л тохиолддог зүйлс байна. Бидний хэмжээнд үнэхээр удирдамж, тушаалууд хангалттай байгаа тэгэхээр эдгээр асуудлуудаа шийдвэрлэж цаашдын арга хэмжээг идэвхитэй хийх үйл ажиллагааруу чиглэх хэрэгтэй байна. ЭМЯ 21 аймаг 9 дүүргээр ЭМЯ-ны хэмнэгдсэн төсвөөр маш богино хугацаанд айлчлаад үйл ажиллагааны хэрэгжилтийг хянах хэрэгтэй санагдаж байна.

Хариулт:

Шийдвэр:

ҮЗЗ-ийн Ажлын Албанаас дээр хөндөгдсөн асуудал, зөвлөмжүүдийг нэгтгэн тусгаж ажлын хэсгийн гишүүдэд хянуулан ЭМСайдын нэр дээр албан бичиг хүргүүлэн шийдвэрлүүлж, улмаар хэрэгжсэн үйл ажиллааны талаарх танилцуулгыг ЭМЯ-наас ҮЗЗ-ийн дараагийн буюу 81 дэхь удаагийн хурлаар мэдээллэх;

ҮЗЗ, ХЗН-ийн зүгээс нэгдсэн хяналт тавьж, шаардлагыг цаг тухайд нь хүргүүлж, эргэн хянах;

ҮЗЗ-ийн дэмжлэгт хяналтын ажлын удирдамжийг ҮЗЗ-ийн ажлын алба дахин боловсруулж ҮЗЗ-ийн нийт гишүүдээс саналыг авч тусган дараагийн ҮЗЗ-ийн хурлаар танилцуулан батлах хэрэгтэй гэж гишүүд хэлэлцэн баталлаа.

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар

Зөвшилцөл	х			
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх	
			Нууц санал хураалт	
		Дэмжсэн>		17
		Эсрэг>		
				Санал өгөхөөс түдгэлзэх

Хөтөлбөр #6 **ҮЗЗ-ийн 2018-2019 оны санхүүгийн тайлан**
Асуулт хариулт

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)> **Үгүй**

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

Б.Оюундарь, ҮЗЗ-ийн Ажлын Албаны зохицуулагч ҮЗЗ-ийн 2018-2019 оны санхүүгийн тайланг/Хавсралт 5-д оруулав./ ҮЗЗ-ийн нийт гишүүдэд танилцууллаа.

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

МҮЭ	Б.Мягмар: Аллантай уулзах явцдаа уул уурхайн компаниудын дунд нөлөөллийн уулзалт зохион байгуулах санал тавьсан. Энэ үйл ажиллагааг үлдэгдэл санхүүжилтээр зохион байгуулах талаар хариу өгнө гэсэн. Ямар нэг хариу өгсөн үү?		
ҮЗЗ	Б.Оюундарь: Одоогоор ямар нэг хариу өгөөгүй байгаа. Эргэж очоод холбогдох мэргэжилтнээс тодруулаад хариу өгнө гэж найдаж байна		
Хариулт:			
Шийдвэр:			
Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар			
Зөвшилцөл	х		
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх
			Нууц санал хураалт
		Дэмжсэн>	
		Эсрэг>	
		Санал өгөхөөс түдгэлзэх	
Хөтөлбөр #7	ҮЗЗ-ийн 2019-2020 оны санхүүжилтийн хүсэлт ҮЗЗ-ийн өөрийгөө үнэлэх үнэлгээ Асуулт хариулт		
Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.			
Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>			Үгүй
Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй			
Б.Оюундарь, ҮЗЗ-ийн Ажлын Албаны зохицуулагч ҮЗЗ-ийн 2019-2020 оны санхүүжилтийн хүсэлт болон ҮЗЗ-ийн өөрийгөө үнэлэх үнэлгээг /Хавсралт 6-д оруулав./ ҮЗЗ-ийн нийт гишүүдэд танилцууллаа. ҮЗЗ-ийн гишүүдэд хүргүүлсэн үнэлгээний хуудсыг нэгтгэн танилцуулж байгааг санууллаа.			
Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга			
ТБ	Ж.Мөнхжаргал: Энэ шилжилтийн үеийн төлөвлөгөөг өмнө нь санхүүжилт гаргаад хийсэн гэсэн мэдээлэл ирж байсан. Тэр яасан болоод энд дахин яригдаад байгаа хэрэг вэ?		
ҮЗЗ	Б.Оюундарь: Миний мэдэж байгаагаар Тогтвортой байдал, шилжилтийн үеийн төлөвлөгөө боловсруулах Ажлын хэсгийн сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлаж тухайн үед ҮАБЗ сонгогдон боловсруулж ЭМЯ хүлээн авч, улмаар ГС-д өргөн барихад ГС хүлээн аваагүй. Улмаар дахин боловсруулах хэрэгцээ гарсаны дагуу ЭМС-дад ажлын хэсэг байгуулах тухай албан хүсэлт илгээсэн. Хүсэлтийн хариу ирмэгц тус зардал нь ажлын хэсгийн гишүүдэд зориулагдах болно.		
ТБ	Ж.Мөнхжаргал: ҮЗЗ-ийн үйл ажиллагаанд гадаад оронд, тэр дундаа урд хөрш БНХАУ-ын Сүрьеэгийн эмнэлэг, судалгааны төвд туршлага судлах үйл ажиллагаа зохион байгуулах нь үр дүнтэй тул тус саналыг оруулж байна.		
ХОН	Г.Нямпүрэв: 2018 онд ОУ-ын ДОХ-ын 22 дахь хурал болсон ба үр дүнгээ ихээр өгсөн хурал болсон. Үүнтэй ижил Ази номхон далайн бүсийн олон улсын хурал энэ жилийн 9 сард товлогдсон тул үүнд оролцох санхүүжилтыг оруулах саналтай байна.		

ТБ	М.Зэндмаа: ҮЗЗ-ийн танилцах айлчлалын санхүүжилтыг 10,500 ам.доллар болгон нэмэгдүүлж улмаар энэ төрлийн үйл ажиллагааны тоог ихэсгэх саналтай байна.
ХЭҮК	Ц.Адъяахишиг: ҮЗЗ-ээс танилцах айлчлалын товыг зарлахаасаа өмнө нийт гишүүдээс хэдэн сард явах бололцоотойг нь асууж тодруулж байж үйл ажиллагааг төлөвлөх хэрэгтэй.
ҮЗЗ	Б.Оюундарь: Дээрх саналуудаас үзхэд 2018-2019 оны хэмнэгдсэн төсвөөр гадаад улсад туршлага судлах үйл ажиллагааг зохион байгуулаад, уул уурхайн салбар дундын нөлөөллийн ажлыг хөтөлбөрийн санхүүжилтээс гаргуулан зохион байгуулах боломж харагдаж байна.

Харнулт:

Шийдвэр:

2018-2019 оны санхүүжилтйн зардалд хэмнэгдсэн төсвийг гадаад оронд туршлага судлах, уул уурхайн дээд хэмжээний уулзалт зохион байгуулах чиглэлийг дараагийн төсөлдөө тусгах замаар гишүүдийн саналыг тусган ҮЗЗ-ийн 2019-2020 оны санхүүжилтийн хүсэлт болон ҮЗЗ-ийн өөрийгөө үнэлэх үнэлгээний хуудсыг боловсруулан Глобаль Санд илгээх саналыг гишүүд санал нэгтгэйгээр дэмжин баталлаа.

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар

Зөвшилцөл	х			
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх	х
			Нууц санал хураалт	
		Дэмжсэн>		17
		Эсрэг>		
		Санал өгөхөөс түдгэлзэх		

Хөтөлбөр #8	Бусад: Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ/Сүрьеэгийн төслүүдийн гэрээний болзолт нөхцөлийн биелэлтийн талаар танилцуулах Глобаль Сангийн дэмжлэгтэй төслүүдийн зохицуулагч А.Оюунбилэгт хүндэтгэл үзүүлэх
--------------------	--

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)> Үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ/Сүрьеэгийн төслүүдийн гэрээний болзолт нөхцөлийн биелэлтийн талаар **С.Ганзаяа**, ХЗН-ийн Сүрьеэгийн хөтөлбөрийн мэргэжилтэн, **Б.Гансүх**, ХЗН-ийн ДОХ-ын хөтөлбөрийн мэргэжилтэн танилцууллаа.

С.Ганзаяа: Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ/Сүрьеэгийн төслийн гэрээний нөхцөлийн биелэлт:

1. Тогтвортой байдал, шилжилтийн үеийн төлөвлөгөө-ЭМЯ -ны Бодлого төлөвлөлтийн газар ХӨСҮТ, 2019 оны 3 сарын 1– Хийгдэж эхлээгүй байна.
2. Эрүүл мэндийн бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийн үйл ажиллагааны стандарт удирдамж ЭМЯ-ны Эм үйлдвэрлэл технологийн газар ХӨСҮТ-2018 оны 5 сарын 31нд өргөн барих байсан ч хугацаа хожимдож 2018 оны 11 сарын 28-нд хүлээлгэн өгсөн.

3. GeneXpert шинжилгээг өргөжүүлэх төлөвлөгөө ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн газар, Эм үйлдвэрлэл технологийн газар, ХӨСҮТ хамтран 2018 оны 12 сарын 31-нд хүлээлгэн өгөх байсан боловч ЭМЯ-наас бодлогын баримт бичиг хараахан гараагүй байгаа тул 2019 оны 6 сард хүргүүлэхээр ГС-аас зөвшөөрөл авсан.
4. ДОХ, Сүрьеэгийн тусламж үйлчилгээ, хяналтанд төр хүвийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх удирдамж-ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, ХӨСҮТ, МӨАУМХ-2019 оны 1 сарын 1-нд хүргүүлэх ажлын хүрээнд хариуцсан байгууллагууд нь баримт бичгээ боловсруулаад ЭМЯ-д өргөн барьсан. ДОХ-ын төслийн хувьд англи хэлээр хөрвүүлэгдээд ЭМСайдын хэмжээнд батлагдах шатандаа явж байгаа тул энэ сардаа багтаан өргөн барих боломжтой байна.
5. ДОХ/Сүрьеэгийн үндэсний хяналт шинжилгээ үнэлгээний төлөвлөгөө-ЭМЯ-ны Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газар, ХӨСҮТ-2018 оны 3 сарын 31 – Боловсруулсан.

Ажлын хэсгийн нэмэлт саналыг дахин сайжруулахаар буцаагдсан.

Тиймээс эдгээр болзолт нөхцлүүд буцаагдаж байгаа талаар ГС-ийн МУ-г хариуцсан менежер Аллантай ярилцаж, зөвшилцсөн.

6. Хүний нөөцийн стратеги-ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, ХӨСҮТ, МСЭМХ-2018 оны 12 сарын 31-нд хүлээлгэн өгөх- Үүнд ЗГ-ын хөтөлбөрийг оруулна.
7. Сүрьеэгийн тусламж үйлчилгээ, хяналтанд төр хүвийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх удирдамж -ЭМЯ, Бодлого төлөвлөлтийн газар, ХӨСҮТ, МӨАУМХ –ЭМС-ын төрийн үйл ажиллагааг ТББ хэрэгжүүлэх тушаалын хүрээнд үйл ажиллагааг МӨАУМХ хийх үүднээс дээрх 2 болзлын тайлангийн хамт 2019 оны 2 сарын 28-ны өдөр хүргүүлэхээр төлөвлөж байна.

Б.Гансүх: ДОХ-ын төслийн гэрээний нөхцөлийн хувьд сүрьеэгийн төслөөс харьцангуй бага болзолт нөхцөлтэй. Тогтвортой байдал, шилжилтийн үеийн төлөвлөгөөнөөс бусад нь хэрэгжсэн бөгөөд ГС-д хүргүүлсэн. Тухайлбал:

1. Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө үйл ажиллаганы сургалт, хөтөлбөрийн төлөвлөгөөг явуулж батлуулах хэрэгтэй байсан нь төсөл бичигдэх явцад хийгдсэж дууссан.
2. СХА менежментийн төлөвлөгөөг боловсруулах даалгаврыг хийж гүйцэтгэн 2018 оны 8 сард ГС-д өргөн барьсан. Энэ нь ГС-ын нийт СХА байгууллагууд нэгдсэн нэг санхүү, ханган нийлүүлэлт, үр дүн үнэлгээ, өдөр тутмын үйл ажиллагааны нэгдсэн нэг удирдамжтай болсон. Хэдий өмнө байсан боловч энэ нь хөтөлбөр бүрт тусдаа байсанг базаж нэгтгэн сайжруулсан.
3. 2017-2021 онд хэрэгжихээр батлагдсан ЗГ-ын “Халдварт өвчинтэй тэмцэх, хянах үндэсний хөтөлбөр”-ийн дагуу ДОХ/БЗДХ-ын үндэсний хяналт шинжилгээний төлөвлөгөөг боловсруулах байсан. Энэ ажил үндсэндээ боловсруулагдаад англи хэлрүү орчуулагдсан. Одоо сайдын тушаалаар батлагдах хамгийн сүүлийн шат л үлдсэн байгаа. ГС-ийн МУ-г хариуцсан Хяналт, шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн Памелад ЭМЯ-ны энэ асуудлыг хариуцсан мэргэжилтнүүд болон ХЗН-ийн мэргэжилтнүүд уулзаад эцсийн байдлаар бэлэн болсон ч Сайдын тушаалыг хүлээж байна. Одоогийн байдлаар ямар нэг нэмэлт санал ирээгүй.
4. Эдгээр хугацаа зааж өгсөн үйл ажиллагаанаас Шилжилтийн үеийн төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй байна. Энэ төлөвлөгөөний хувьд бидний зүгээс төсөл дуусахад эдгээр үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар өргөн хүрээнд авч хэлэлцэн, боловсруулах ёстой. Түүнчлэн МУ-г хариуцсан менежертэй уулзаад өмнө хийгдсэн санал дээрээ тулгуурлан Шилжилтийн үеийн төлөвлөгөөгөө боловсруулах ба сүрьеэгийнх удахгүй хийгдэнэ. Тэгэхээр энэ үйл явц дууссаны дараа ХЗН, ЭМЯ, ҮЗЗ шилжилтийн үеийн төлөвлөгөө гэж юу байх талаар нилээд ойлголттой болох байх гэж бодож байна. Үүнтэй холбоотойгоор

үүнийг өргөн барих хугацааг тодорхой хэмжээгээр хойшлуулах хүсэлтийг ГС-д тавих байх. Учир нь бид хугацааг хойшлуулахгүй бол гэрээнд тусгагдсан гэрээний бүх нөхцлүүд маань дараа дараагийн санхүүжилт орж ирэх санхүүжилтийн шилжүүлэгтэй шууд уялдаатай байдаг. Тэгэхээр ямар нэг зөвшилцөлгүйгээр хойшлуулбал үйл ажиллагааны санхүүжилт гацах эрсдэлтэй.

Глобаль Сангийн дэмжлэгтэй төслүүдийн зохицуулагч А.Оюунбилэгт хүндэтгэл үзүүлэх ёслолын арга хэмжээ боллоо. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд **ҮЗЗ-ийн дарга Б.Мягмар** талархалыг гардуулан үг хэллээ. Үүнд:

“Эрхэм хүндэт А.Оюунбилэг танаа, Монгол Улсын Эрүүл Мэндийн салбарт олон жил тасралтгүй үр бүтээлтэй ажиллахын зэрэгцээ ХДХВ/ДОХ, Сүрьеэ өвчинтэй тэмцэх Глобаль Сангийн төслийг Монгол Улсад 15 жил амжилттай хэрэгжүүлэх их үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж, Монгол хүний эрүүл мэндийн төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэж зүтгэлийг тань өндрөөр үнэлж энэхүү "ТАЛАРХАЛ"-ыг гардуулав. Танд эрүүл энх, аз жаргал, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Глобаль сангийн Монгол Улс дахь Үндэсний Зохицуулах Зөвлөл”

А.Оюунбилэг, ХЗН-ийн зохицуулагч асан, үг хэлж, нийт хамт олондоо цаашдын ажил амьдралд амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөлөө.

Н.Цогзолмаа, ХЗН-ийн шинээр томилогдсон зохицуулагч, миний бие ЭМЯ-д 15 жил ажилласан, түүнээс өмнө Мэргэжлийн хяналт, ЭМЯ-ны харьяа ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг болох Эмнэлгийн тусламжийн газар ажиллаж байсан. Тэгэхээр өнөөдөр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа болон цаашдын үйл ажиллагааг үргэлжлүүлэн авч явна. Ерөнхийдөө ЭМЯ-д ажилласан олон жилийн туршлага болоод өөрийн мэргэжлийн чиглэлээр ажиллаж байгаа тул энэхүү үйл ажиллагааг улам чанаржуулан сайжруулж авч явах болно.

Шийдвэр:

Гэрээний болзолт нөхцлийн биелэлт 75-80%-тай явж байгаа. ҮЗЗ-ийн хурлаар ХЗН-ээс асуудал танилцуулах/хурлын хэлэлцэх асуудлын дараалалд оруулсан бол заавал урьдчилан бэлтгэсэн материалыг ҮЗЗ-ийн гишүүдэд тараах, ҮЗЗ-ийн ажлын албанд дэмжлэг үзүүлж ажиллах шаардлагатайг ХЗН-ийн зохицуулагч Н.Цогзолмаад даалгав.

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар

Зөвшилцөл	х			
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх	
			Нууц санал хураалт	
		Дэмжсэн>		
		Эсрэг>		
			Санал өгөхөөс түдгэлзэх	

ШИЙДВЭР, АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Хөтөлбөр		ХАРИУЦАЖ БУЙ ХҮН	ХУГАЦАА
хөтөлбөр#5	ҮЗЗ-ийн Ажлын Албанаас дээр хөндөгдсөн асуудал, зөвлөмжүүдийг нэгтгэн тусгаж ажлын хэсгийн гишүүдэд хянуулан ЭМСайдын нэр дээр албан бичиг хүргүүлэн шийдвэрлүүлж, улмаар хэрэгжсэн үйл ажиллааны талаарх танилцуулгыг ЭМЯ-наас ҮЗЗ-ийн дараагийн буюу 81 дэхь удаагийн хурлаар мэдээллэх шаардлагатай. ҮЗЗ, ХЗН-ийн зүгээс нэгдсэн хяналт тавьж, шаардлагыг цаг тухайд нь	ҮЗЗ-ЭМЯ-ХЗН	ЭМЯ-НААС ҮЗЗ-ИЙН 81 ДЭХ ХУРАЛД ТАНИЛЦ УУЛАХ

	хүргүүлж, эргэн хянах хэрэгтэй гэсэн саналыг гишүүд 100% гараа өргөн баталлаа. ҮЗЗ-ийн дэмжлэгт хяналтын ажлын удирдамжийг ҮЗЗ-ийн ажлын алба дахин боловсруулж ҮЗЗ-ийн нийт гишүүдээс саналыг авч тусган дараагийн ҮЗЗ-ийн хурлаар танилцуулан батлах хэрэгтэй гэж гишүүд хэлэлцэн баталлаа.		
хөтөлбөр#7	Гишүүдийн саналыг тусган ҮЗЗ-ийн 2019-2020 оны санхүүжилтийн хүсэлт болон ҮЗЗ-ийн өөрийгөө үнэлэх үнэлгээний хуудсыг боловсруулан Глобаль Санд илгээх саналыг гишүүд санал нэгтгэйгээр дэмжин баталлаа.	ҮЗЗ	
хөтөлбөр#8	Дараагийн удаагийн хурал дээр ХЗН-ээс ямар нэг зүйл танилцуулахаар хурлын хөтөлбөрт оруулсан бол заавал урьдчилан бэлтгэсэн материалыг ҮЗЗ-ийн гишүүдэд тараах шаардлагатай гэдгийг дахин сануулах байна. Хурлын цаг давчуу байхад гишүүд зохих материалтай танилцаад явах нь илүү хүртээмжтэй байна шүү дээ. Энэ асуудал урд нь ч бас гарч байсан тул ХЗН-ийн зохицуулагч энэ асуудлыг анхааралдаа авч ажиллана гэж найдаж байна.	ХЗН, зохицуулагч	

ДАРААГИЙН ХУРАЛ(ОГНОО, ХӨТӨЛБӨР)	
Огноо	2019 оны 6 дугаар сар
Хэлэлцэх асуудлууд	Хөтөлбөр


Хавсрах материал	Тохирох нүдийг бөглөнө үү	
	Тийм	Үгүй
Оролцогчдын бүртгэл	X	
Хөтөлбөр	X	
Бусад /илтгэлүүд/	X	
Хавсралт 1-10	X	

БЭЛТГЭЛ АЖИЛ(Тохирох нүдийг бөглөнө үү)			
	Тийм	Үгүй	
Хурлын тов, хөтөлбөрийг хурал болохоос 7 хоногийн өмнө хүргүүлсэн эсэх	x		7 хоног
Бүртгэлийн хуудас	x		Хуралд оролцсон бүх хүмүүс
Хурлын тэмдэглэлийг хурал болсоноос 7 хоногийн дотор явуулах	x		7 хоног
Хүргүүлсэн тэмдэглэлд гишүүд саналаа өгөх, нэмэх, батлах	x		Цахим хаягаар
Хурлын тэмдэглэлийг гишүүд болон оролж ирсэн төлөөлөлд хүргүүлж байх	x		ҮЗЗ-ийн цахим хуудсанд 15 хоногийн дотор байршуулах


ТОВЧИЛСОН ҮГ:	
Товчлол	Утга

ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ЗГ	Засгийн Газар
СЯ	Сангийн Яам
ТБ	Төрийн Байгууллага
ҮЗЗ	Үндэсний Зорицуулах Зөвлөл
ТББ	Төрийн Бус Байгууллага
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
НУБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ТНБД	Төрийн Нарийн Бичгийн Дарга
ХЗН	Хөтөлбөр Зохицуулах Нэгж
ЭМ	Эрүүл Мэнд
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ҮАБЗ	Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл
ҮХА	Үндсэн Хүлээн Авагч
СХА	Салбар Хүлээн Авагч

БАТАЛСАН:

Нэр>	Б.Мягмар	DATE >	2019 оны 2 сарын 28
Албан тушаал>	ҮЗЗ-ийн дарга	Гарын үсэг>	

ХЯНАСАН:

Нэр>	Б.Оюундарь	Огноо>	2019 оны 2 сарын 28
Албан тушаал>	ҮЗЗ-ийн зохицуулагч	Гарын үсэг>	

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Нэр>	Л.Номин-Эрдэнэ	Огноо>	2019 оны 2 сарын 28
Албан тушаал>	ҮЗЗ-ийн ажилтан	Гарын үсэг>	